



## ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН “БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 4/10.

Бор-Өндөр

Г Хичээл, сургалтын үйл ажиллагааг цахим  
хэлбэрээр зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 33 дугаар зүйлийн 33.3.1, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/554 дугаар тушаал, Боловсролын ерөнхий газрын зөвлөмж, сумын эрүүл мэндийн газрын 162 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Хүйтний эрч чангарч сумын хэмжээнд томуу, томуу төст өвчний дэгдэлт ихсэж байгаатай холбогдуулан суралцагчдын 2023-2024 оны хичээлийн жилийн хоёрдугаар улирлын танхимиын хичээл, сургалтыг 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс 12 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл хугацаанд зайн, цахим хэлбэрээр зохион байгуулсугай.
- Тушаалын хэрэгжилтийг хангаж, цахим хэлбэрээр хичээл, сургалтыг чанартай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг сургалтын менежер (М.Нармандах), хичээл, сургалтыг чанартай зохион байгуулахыг анги удирдсан багш нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АМАРЖАРГАЛ

